



ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 134

Тавин

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "А" заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Дунд сургуулийн спорт заалны зураг төсөв хийлгэх ажлын урьдчилгаа төлбөр 10000000 (Арван сая) төгрөгийг Байгаль хамгаалах сангаас эргэн төлөгдөх нөхцөлөөр гаргасугай.
2. Дээрх зардлыг Байгаль хамгаалах сангаас гаргахыг Сан хариуцсан нягтлан бодогч (М.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.
3. Спорт заалны барилгын гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан компаниас 10000000 (Арван сая) төгрөгийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэхийг Сумын Засаг даргын орлогч (Ж.Сүнжидмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ж.БАТХӨЛӨГ



481200071